

Тус бичиг нь эх бичгийг ойлгоход тус болгохоор бэлтгэсэн зүйл юм.
Эрүүл мэндийн газраас гаргасан япон хэлээр бичигдсэн эх бичиг нь албан ёсны бичиг болно.

②

_____ ЭМ газар № _____
он сар өдөр

_____ танаа

_____ эрүүл мэндийн газрын дарга

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг шаардах бичиг

Та “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ба халдварт өвчнийг эмчлэх тухай” хуулийн (цаашид “хууль” гэх) 6-р зүйлд заагдсан тусгай заалттай халдварт өвчин (Ковид-19) -ийн халдвартай болох нь тогтоогджээ.

Иймд Ковид-19-ийг тусгай заалттай халдварт өвчин гэж тодорхойлсон болон бусад Засгийн газрын тушаалын 3-р зүйлийн заалтад үндэслэн, хуулийн 19-р зүйлийн 1 дэх хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох)-ийг мөрдлөг болгож, доор дурдсаны дагуу таныг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг шаардаж байна.

Харин, хэрэв энэ шаардлагыг даган мөрдөхгүй бол хуулийн 19-р зүйлийн 3 дахь хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох)-ийг мөрдлөг болгож, албаар эмнэлэгт хэвтүүлэх арга хэмжээ авч болзошгүй.

1 Хэвтэн эмчлүүлэх эмнэлэг

(1) Эмнэлгийн нэр

(2) Хаяг

2 Эмнэлэгт хэвтэх ёстой өдөр

он сар өдөр болохоос өмнө эмнэлэгт хэвтэх хэрэгтэй.

3 Хэвтэн эмчлүүлэх хугацаа

он сар өдрөөс он сар өдөр хүртэл

4 Эмнэлэгт хэвтэхийг шаардах учир шалтгаан

(1) Халдварт өвчний тархалтыг зогсоох зорилгоор

(2) Халдварт өвчний шинж тэмдэгтэй учраас

5 Бусад

Та хуулийн 22-р зүйлийн 3 дахь хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох)-ийн заалтын дагуу эмнэлгээс гарах хүсэлт гаргах боломжтой бөгөөд түүний үр дүнд уг халдварт өвчин үүсгэгч вирус илрэхгүй байх эсвэл тус халдварт өвчний шинж тэмдэг арилсан гэдэг нь батлагдвал хуулийн 22-р зүйлийн 1 дэх хэсэг (хуулийн 26-р зүйлийг мөрдлөг болгох) заалтад үндэслэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хугацаа дуусгавар болно.

Түүнчлэн хуулийн 24-р зүйлийн 2-ын 1 дэх хэсгийн заалтад үндэслэн таныг эмнэлэгт хэвтэж байсан хугацаанд хэрхэн хүлээж авсан талаар бичгийн хэлбэрээр эсвэл аман хэлбэрээр гомдол гаргах эрхтэй.

Хариуцсан ажилтан _____